



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА С.БҮРЭНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2014.05.15 № 01/3985
танай _____-ны № _____-т

Авлигын эсрэг арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын Ажлын хэсэг 2014 оны 2 дугаар сарын 23-наас 3 дугаар сарын 6-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлагууд болон аймгийн 17 сумдад авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалтай танилцлаа.

Ажлын хэсэг ажиллах хугацаандаа аймаг, сумдын иргэд олон нийттэй уулзан санал хүсэлтийг нь сонсож, тэдгээрийн гомдол мэдээллийн мөрөөр ажилласны зэрэгцээ иргэдэд болон нийтийн албан тушаалтанд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулж, авлигын эсрэг үйл ажиллагааг хариуцдаг эрх бүхий албан тушаалтнуудад төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн мэргэжил арга зүйн туслалцааг үзүүллээ.

Тус газраас орон нутгийн захиргааны байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрхэн зөв, оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, үнэлэхтэй холбоотойгоор заавар, зөвлөгөө, аргачлалаар хангах ажлыг авлигын эсрэг хууль эрх зүйн орчинд нийцүүлэн шат дараалалтай хэрэгжүүлж ирсэн билээ.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.1.7, 6.1.8, 6.1.11, 6.1.13 заалтуудын хэрэгжилт зохих түвшинд байх бөгөөд төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг дүгнэх хуудсын мөрөөр үнэлж, дүнг танилцуулдаг, төрийн байгууллагын авлига, хүнд суртал ямар түвшинд байгаа талаарх санал асуулга явуулж дүнг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл бүхий хэлэлцүүлэгт мэдээлдэг, Авлигын эсрэг үйл ажиллагааг эрхлэх орон тооны бус зөвлөл ажиллуулдаг зэрэг сайн туршлагууд байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Харин Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7, 8, 9 дүгээр зүйлүүдээр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийн болон орон нутагт дахь төсөл хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, иргэд олон нийтээс төсвийн хөрөнгө орлого, зарцуулалтын байдалд тавих хяналтын механизм сул байна гэж дүгнэлээ. Тухайлбал,

Нэг. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийн хэрэгжилт:

007790

1/ Байгууллагын түвшинд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг шинээр тогтоон мөрдүүлэхтэй холбоотой арга хэмжээг зохих түвшинд авч, хэрэгжүүлээгүй;

2/ Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт Авлигатай тэмцэх газраас дүгнэлт гаргуулах, ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлэх, тайлбар гаргах, давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх зэргийг хэрэгжүүлдэггүй бөгөөд энэ талаарх бүртгэл хөтлөлтийг хэвшүүлээгүй;

3/ Засаг даргын Тамгын газар болон Цагааннуур, Орхонтуул, Түшиг, Хүдэр сумдад албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалтыг зөрчиж хандив хүсэх, зохион байгуулах, хандивлагчтай холбоотой шийдвэр гаргадаг явдал түгээмэл;

4/ Ашиг сонирхлын зөрчилтэй болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалтай шийдвэрүүд гаргах, төсвийн болон хандивын хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй;

5/ Төсөв хөрөнгийг батлах, үнэ тариф тогтоохдоо хуулиар эрх олгоогүй субъект баталдаг, эрх зүйн баримт бичгийг гаргахдаа хүчингүй болсон хуулийн зүйл, заалтыг үндэслэсэн ;

6/ Төсөв санхүү, худалдан авах ажиллагаатай холбогдох мэдээлэл иргэд олон нийтэд ойлгогдохуйц түвшинд нээлттэй бус, хэлбэрийн төдий байгаа зэрэг зөрчлүүд байна.

Хоёр. Сум хөгжүүлэх сангийн талаар:

Ажлын хэсэг сумдад Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийн байдалтай танилцахад:

1/ Төслийн талаарх мэдээлэл ил тод бус;

2/ Сумдын удирдлагууд өөрийн хамаарал бүхий этгээдэд зээл олгох явдал нийтлэг байх бөгөөд ийнхүү шийдвэрлэхдээ ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг гаргадаггүй;

3/ Сан нь Төрийн санд тусгай данстай байх шаардлагыг хангаагүй;

4/ Зээлийн журмыг зөрчиж, зориулалтын бусаар зарцуулдаг;

5/ ИТХ-аас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоогоогүй зэрэг болно.

Иймээс дээрх зөрчил, дутагдалд дүгнэлт хийж, аймгийн хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, дүнг энэ оны 7 дугаар сарын 01-ний дотор тус газарт ирүүлнэ үү:

1/ Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хандив, давхар ажил эрхлэлт, бэлэг, мэдэгдэл, урьдчилсан мэдүүлэгтэй холбоотой бүртгэл хөтлөлтийг бий болгох, улмаар хэвшүүлэх;

2/ сумд тус бүрээр давхар ажил эрхлэлттэй холбоотой болон хамаарал бүхий этгээдийн ажил эрхлэлтийн нэгдсэн судалгааг нээлттэй болгох;

3/ төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг явдлыг таслан зогсоох, нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

4/ аймаг, сумдын цахим хуудас болон төрийн байгууллага бүрийн мэдээллийн самбараар иргэд шаардлагатай мэдээллээ авах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, хүний нөөцийн болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих түвшинд мэдээлэх, мэдээллийн тасралтгүй байнгын ажиллагааг хангах;

5/ орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, түүний сонгон шалгаруулалттай холбогдох дүрэм, журмыг ил тод, нээлттэй болгох;

6/ сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангуудын зээлийн тухайн жилийн төсөв, төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүн, төсөл шалгаруулах хугацааг сурталчлах тогтсон хэлбэрүүдтэй байх, ирсэн төслийн саналууд, шалгарсан төслүүдийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй иргэд олон нийт чөлөөтэй танилцах боломж олгох;

7/ аймаг болон сумдын төсөв хөрөнгийг батлах, үнэ тариф тогтоохдоо холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлах /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид/-ээр бус;

8/ аймаг, сумдын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм журмыг хянан үзэж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, үндэслэлгүй төлбөр, хураамж тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох;

9/ орон нутагт Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах, шагнал урамшуулал олгохтой холбоотой зардлыг Засгийн газраас тогтоосон жишиг хэмжээнд багтаан баталж байхыг чанд мөрдүүлэх арга хэмжээ авах;

10/ албан тушаалтны ХАСМХОМ-ийн талаар мэдээлэл авах эрхийг иргэд олон нийтэд ойлгуулж, таниулах, тэдгээрт холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх зэрэг болно.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



Н.ГАНБОЛД